МОНГОЛ БАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2009 оны 03 сарын 20 өдөр Дугаар 164 Улаанбаатар хот

"Гадаад валютын дуудлага худалдааны журам",
"Гадаад валютын дуудлага худалдаа
явуулах заавар"-ыг батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 6, 22 дугаар зүйлийн 2, 28 дугаар зүйлийн 2 дахь заалт, Валютын зохицуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Гадаад валютын дуудлага худалдааны журам"-ыг нэгдүгээр хавсралтаар баталж 2009 оны 3 дугаар сарын 23-ны өдрөөс мөрдсүгэй.

2."Гадаад валютын дуудлага худалдаа явуулах заавар"-ыг хоёрдугаар хавсралтаар баталж 2009 оны 3 дугаар сарын 23-ны өдрөөс мөрдсүгэй.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2002 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 84 дүгээр тушаал, 2003 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 409 дүгээр тушаалын 2 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэхүү журам, зааврыг мөрдөж ажиллахыг Валют, эдийн засгийн газар (Г.Дэлгэрмаа), Төлбөр тооцоо, бүртгэлийн газар (М.Амгалан)-т тус тус үүрэг болгосугай.

5.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (Г.Тогтохбаатар)-т даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ Л.ГҮРЭВДОРЖ